

ГЭР БҮЛИЙН ОРЧИНД ХҮҮХДИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ ХЭР ЗЭРЭГ ХАНГАГДАЖ БАЙНА ВЭ?

С.Тулга доктор

Orcid: 0009-0004-6141-4597

Хөдөлмөр, нийгмийн харилцааны дээд сургууль

Abstract: *In the country, in the field of education, and in every family and parent, there is a need to provide children with a civic education that preserves national traditions and is in connection with modern world. The rapid development of society, the economy, technology, globalization and the information age have led to significant changes in the factors that affect the education of children. Many researchers agree that the family, as a social institution, is the primary environment for children's development, education, and maturity. The innate nature of childhood is to love, protect, and grow up to be loved by adults. As the child grows and develops, new needs arise for them, and since the child cannot meet those needs on their own, they are met with the care and support of family members.*

Key words: *children, accidents, family and safety, child safety.*

Оршил

Монгол улсын хэмжээнд 2021 оны байдлаар хүн ам 3.409.939 байгаагаас, насны бүтцийн хувьд 0-18 насны 1.272.527 буюу 37.32 хувийг хүүхэд эзэлж байна (ҮСХ, 2022). Нийгмийн хөгжлийн тулгуур болсон хүүхэд, залуучуудын бүлэг, нийтлэгийн хэрэгцээ, сонирхол, хүмүүжил, төлөвшил, орчны аюулгүй байдлын тухай асуудал зайлшгүй яригдана. ийг харахад Хүүхдийн аюулгүй байдал гэр бүлдээ төдийгүй нийгмийн хувьд хамгаалагдсан байх ёстой. Хүүхэд эмзэг, өөрийгөө хамгаалах чадвар багатай тул өөрт нь учирч болзошгүй аливаа эрсдлээс хамгаалагдах ёстойг олон улсын хэмжээнд баталгаажуулсан байдаг ба монгол улсын хууль эрх зүйн актуудад ч тусгагдсан байдаг.

НҮБ-аас Хүүхдийн эрхийн тухай конвенцийг 1989 онд батлан гаргасан. Тус конвенциор хүүхдийг өсгөн хүмүүжүүлэхэд эцэг эхчүүд нэн тэргүүнд үүрэг хүлээдэг. Эцэг эх нь хүүхдийн хувьд хамгийн чухал багш, чиглүүлэгч, үлгэрлэн дууриах хүн юм (Joan E.Durrant, 2010) (Е.Дюррант, 2008). Монгол улс Хүүхдийн эрхийн тухай хууль, Хүүхэд хамгааллын хуулийг 2016 онд баталсан. Хүүхэд хамгааллын тухай хуулийн 5-р зүйлд эцэг эх, гэр бүлийн гишүүд, асран хамгаалагч, харгалзан дэмжигч нь хүүхэдтэй холбоотой эрх, үүргээ урвуулан ашиглах, хүүхдийг үл хайхрах, дарамт, хүчирхийлэл, мөлжлөгийн бүх хэлбэр, аливаа гэмт хэрэг, зөрчлөөс хамгаалах арга хэмжээг авахыг мөн зааж өгсөн. Хүүхдийн эрхийн тухай хуулийн 7-р зүйлд хүүхэд гэмт хэрэг, зөрчил, хүчирхийлэл, бие махбодын шийтгэл, сэтгэл санааны дарамт, үл хайхрах байдал болон мөлжлөгийн аливаа хэлбэрээс нийгмийн бүх орчинд хамгаалагдах эрхтэй гэж заасан байдаг. Тэгэхээр хүүхдийн хувьд хамгийн аюулгүй тайван орчин нь гэр бүлийн орчин бөгөөд хүүхдийг хамгаалах үүргийг нэн тэргүүнд эцэг эхчүүд хүлээдэг байна (ХНХЯ, 2016). Хүүхдийн эрхийн тухай хуулийн 5.2. хүүхэд эрүүл өсч бойжих, аюулгүй орчинд амьдрах, аливаа хүчирхийллээс ангид байх эрхтэй”, мөн Гэр бүлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлд “хүүхдийг гэр бүлийн дотор эрүүл чийрэг өсгөн хүмүүжүүлэх, хөгжүүлэх, түүний эрх, ашиг сонирхлыг нэн тэргүүнд хамгаалахыг эрхэмлэнэ” гэж заажээ.

Хүүхдийн өсөлт, хөгжил явагдахын хирээр өөрсдөд нь шинээр хэрэгцээ үүссээр байдаг ба тэрхүү хэрэгцээг хүүхэд өөрөө бие даан хангаж чадахгүй учир гэр бүлийн хүмүүсийн анхаарал халамж, дэмжлэг туслалцаатайгаар хангагддаг. Хүүхэд 24 цагийн бараг 80 хувийг гэр бүлдээ өнгөрөөдөг тул хүүхдийн хөгжил, хүмүүжил, төлөвшил, аюулгүй орчинд амьдрах зэрэг олон зүйл нь гэр бүлийн хүрээнд хамгаалагдах ёстой. Хүүхдийн хувьд гэр бүлийн орчин хамгийн аюулгүй байх ёстой. Хариуцлагагүй ээж, аав, асран хамгаалагчийн буруугаас болж, хүүхдийн эрх зөрчигдөх, хохирох, гэмтэж бэртэх, эрсдэлд зан үйлд автдаг ажээ. Гэр бүлийн орчинд хүүхдийн аюулгүй байдал хангагдаагүйгээс хүүхэд хамгийн их хохирдог бөгөөд хүчирхийлэлд өртөх буурахгүй, ахуйн осол гэмтэлд өртөх, эрүүл мэнд, амь насаараа хохирох нь тохиолдол улам бүр нэмэгдсээр байна.

Статистик зарим тоон мэдээлэл, судалгааны ажлууд дээр үндэслэн хүүхдийн аюулгүй байдал гэр бүлийн орчинд хэр хангагдаж байгаа талаар судлан дүн шинжилгээ хийлээ.

2010-2016 оны хооронд улсын хэмжээнд хүүхэд өртсөн зам тээврийн осол 7,150 бүртгэгдэж, зам тээврийн ослын улмаас жилд 50 гаруй хүүхэд, тэр дундаа 0-14 насны хүүхдүүд зам тээврийн ослын улмаас хохирч байгааг тогтоожээ. 2017 онд гэхэд зам тээврийн осолд өртсөн хүүхэд 474 болж, өмнөх оноос 161 тохиолдлоор буюу 51.4%-иар өсжээ (ҮСХ, 2017). Улсын хэмжээнд зам тээврийн ослоор 2016 онд 48 хүүхэд нас барсан бол 2017 онд 59 хүүхэд нас барсны 49 нь орон нутагт хохирсон байна (ЗЦГ, 2018). Зам тээврийн осол, гэмтэл 5 хүртэлх насны хүүхдийн 3 дахь гэмтлийн шалтгаан, 6-18 насны хүүхдийн 2 дахь гол шалтгаан болжээ (ЗЦГ, 2017). Хүүхдүүд ихэвчлэн гэр, сургуулийн хооронд явж байхдаа зам тээврийн осолд өртдөг. Автозамын замбараагүй зохион байгуулалт болон жолоочийн хариуцлагагүй үйлдэл, томчуудын хайхрамжгүй байдал ослын шалтгаан болдог. Хүүхдүүд сургууль, цэцэрлэгийн ойролцоох замаар гарцгүй газраар гүйх, асран хамгаалагчгүй зам хөндлөн гарах, ойртон ирж буй тээврийн хэрэгслийн урдуур гүйх нь осолд гэмтэхэд нөлөөлдөг ажээ. Харин ахуйн осолд 2016 онд 304, 2017 онд 298 хүүхэд өртжээ. ГССҮТ-ийн⁷⁸ 2016 оны мэдээгээр 5 хүртэлх насны хүүхдийн осол гэмтлийн шалтгаант нас баралт хүүхдийн нийт нас баралтын 14.4%-ийг эзэлж байгаа бөгөөд түүний 76.5% нь түлэгдэлтийн, үүнээс 77% нь халуун хоол, цайнд, 23% нь халуун усанд түлэгдсэн байна. Харин 2019-2021 оны тоон үзүүлэлтийг харвал 157 мянган хүүхдээс 83 мянга нь хамгийн аюулгүй амьдрах ёстой гэртээ осолд, гэмтэлд өртсөн байна. Үүнээс 333 хүүхэд эндсэн. 2019-2021 оны хооронд ахуйн осол гэмтлийн тоо байнга өссөн. Тодруулбал, 2019 онд 24 мянга, 2020 онд 28 мянга, 2021 онд 29 мянган хүүхэд гэртээ гэмтэж бэртсэн байна. Мөн эдгээр хүүхдүүдийн 40.1 хувь нь тархины гэмтэл авч байна. 0-18 насны хүүхдүүдийн гэртээ нас барах шалтгааны хамгийн эхэнд амьсгал боогдох орж байна. ГССҮТ-ийн 2019-2021 оны статистик мэдээллээс харахад осол гэмтлийн шалтгаант шинэ тохиолдлын тоо тав хүртэлх насанд хамгийн их байсан бөгөөд гэмтэлд өртсөн гурван хүн тутмын нэг нь 0-15 насны хүүхэд байна гэсэн статистик гарчээ. Осол гэмтлийн шалтгаант шинэ тохиолдлын тоо 2018-2021 онд 5 хүртэлх насанд хамгийн их байна. 2021 онд осол гэмтлийн шинэ тохиолдлын тоо эрэгтэй, эмэгтэй аль ч хүйсэнд 0-4 насанд (эрэгтэй 12.8%, эмэгтэй 16.3%) хамгийн өндөр байгаа 5-аас дээш бүх насанд буурсан үзүүлэлттэй байгаа бол 0-4 насанд жил бүр өсөх хандлага ажиглагдаж байна (ГССҮТ, 2022).

Хүснэгт 1. Хүүхдийн осол гэмтлийн тохиолдолын тоо

Насны бүлэг	2016	2017	2018	2019	2020	2021
0-4	10594	13203	18199	19738	20189	20243
5-9	7899	8970	12423	13854	12947	11541
10-14	6989	8091	10830	13008	10833	9757
15-19	8019	9027	10806	12224	9830	9502
	33501	39291	52258	58824	53799	51043

Эх сурвалж: <https://gemtel.mn/>

Хүснэгт-2 Хүүхдийн осол гэмтлийн тоон үзүүлэлт

	2018	2019	2020
Уналт	24611	28273	29584
Зам тээврийн осол	4711	5984	2628
Түлэгдэлт	3451	4228	1499
Хүчирхийлэл	1715	1753	1686

⁷⁸ ГССҮТ- Гэмтэл согог судлалын үндэсний төв

Амьгүй механик хүчинд өртөх	8100	9395	4244
Амьд механик хүчинд өртөх	4123	5661	1021

Эх сурвалж: ГССҮТ-ийн тайлан

2021 оны байдлаар уналт 24397, зам тээврийн осол 1817, амьгүй механик хүчинд 7707 хүүхдүүд гэмтсэн тоо үзүүлэлт байна (ГССҮТ, 2022). Насны бүлгээс хамааран осол гэмтлийн тэргүүлэх шалтгаан өөр өөр байна. Жишээ нь: Бүх насанд уналт 1-р шалтгаан болж байгаа боловч 5 хүртэлх насанд түлэгдэлт, 5-9 насанд явган явж байх үедээ тээврийн хэрэгсэлд мөргүүлж гэмтсэн тохиолдол 1-р шалтгаан болж, 15-24 насанд амьгүй механик хүчинд өртөлт орж байна. Осол гэмтэлд өртсөн нийт тохиолдлын 44.4% гэртээ, 30.9% гудамж замд гэмтсэн байна. Осол гарах болсон шалтгааны 89.3% нь эцэг эхийн хараа хяналт сулаас, 10.7% нь анхаарал болгоомжгүй байдлаас болсон гэж тогтоожээ. Иймд хүүхдийг осол гэмтлээс урьдчилан сэргийлэх талаар эцэг эхчүүдийн үүрэг хариуцлага, тэдний эрүүл мэндийн боловсрол, хараа хяналтыг дээшлүүлэх, сайжруулах хэрэгтэй байна. Сүүлийн жилүүдэд хүүхдийн нас барсан тохиолдлын 35 хувь нь буюу 3 хүн тутмын нэг нь гэр орон, ахуйн нөхцөлд осолд өртөж нас баржээ. Үүнээс хүүхдийн гэмтэл 30-40 хувийг эзэлж байна.


Улсын хэмжээнд 2020 оны эхний 3 сард 8003 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 1902 (19.2%) оор, гэр бүлийн хүчирхийллийн улмаас үйлдэгдсэн 279 гэмт хэрэг бүртгэгдэж, өмнөх оны мөн үеэс 104 (27.2%) оор тус тус буурчээ. Тус гэмт хэргийн нийт дүнд эзлэх хувь 3.5 байгаа нь өмнөх оны мөн үеэс 0.4 пунктээр буурсан байна. (ҮСХ, ЦЕГ, 2020). Гэхдээ гэр бүлийн хүчирхийллийн улмаас үйлдэгдсэн гэмт хэрэгт 273 иргэн, үүнээс 238 (87.2%) эмэгтэйчүүд, 30 (11.0%) хүүхэд өртөж, хохирсон байна. Гэмт хэргийн улмаас 2022 оны эхний 5 сард 16.5 мянга болж, 941 (5.7%) нь 18 хүртэлх насны хүүхэд хохирсон байна (ҮСХ, 2022). 2020 онд 330 хүүхэд, 2021 онд 345 хүүхэд бэлгийн хүчирхийлэлд өртсөн гэх гомдол бүртгэж, 317 хүүхдэд хэрэг шалгах, шийдвэрлэх хугацаанд нөхцөл байдлын үнэлгээ хийж, 253 хүүхдэд эрх зүйн туслалцаа үзүүлж, 304 хүүхдэд сэтгэл зүйн зөвлөгөө үзүүлжээ. Хүүхдүүдийн хувьд дийлэнхи нь буюу 80.2 хувь нь гэр бүлийн орчинд эцэг эх, асран хамгаалагчдын зүгээс хүчирхийлэлд өртсөн байдаг. Гэр бүлийн нөхцөл байдлыг судлахад тухайн гэр бүлд архины хамааралтай, зан үйлийн өөрчлөлттэй эцэг эх, асран хамгаалагчтай, эрхэлсэн тодорхой ажилгүй, салсан, нийлсэн гэр бүлүүд 60 орчим хувийг эзэлж байна гэсэн судалгаа байдаг. Үр хүүхдээ болзошгүй аюул ослоос хамгаалах нь эцэг эхчүүдийн үүрэг юм.

Сүүлийн үед мэдээлэл технологийн хөгжилтэй уялдан бий болсон тулгамдсан асуудлын нэг бол гар утасны хамаарал, цахим тоглоомонд донтох эмгэг юм. Анх профессор, сэтгэл зүйч Кимберли Янг (Kimberly Young) 1996 онд АНУ-ын Торонто хотноо зохион байгуулагдсан Америкийн сэтгэл зүйн нийгэмлэгийн бага хуралд “Интернет донтолт” хэмээх шинэ эмгэгийн тухай танилцуулж байжээ.

Үндэсний статистикийн газраас хийсэн “Хүүхэд, залуучууд” 2020 онд хийсэн судалгаагаар 6-9 насны нийт хүүхдийн 37.2 хувь, 10-14 насны нийт хүүхдийн 74.7 хувь нь гар утас хэрэглэдэг байна. Сүүлийн жилүүдэд гар утас хэрэглэгчдийн тоо тэр дундаа ухаалаг утас хэрэглэгчдийн тоо хурдацтай өссөөр байна. Технологийн хурдац, нийгмийн хөгжлийн явцад хэрэглэгчдийн тоо өсч байгаа билээ. 0-11 нас ахих тусам гар утасны хэрэглээ нь жигд нэмэгдэж байна. Интэрнэт хэрэглэгдэг 6-14 насны хүүхдүүдийг нас, хүйсийн бүтцээр авч үзвэл нас нэмэгдэх тутамд хэрэглэгчдийн хувь нэмэгдэж байгаа бол хүйсийн хувьд 6-11 насны охидын интэрнэтийн хэрэглээ хөвгүүдийнхээс тодорхой хэмжээгээр бага байна. Харин 12-15 насанд хөвгүүдийнхээс нэмэгдэх хандлагатай байна (ҮСХ, 2020). Хүүхдийн цахим хэрэглээг хянах, цахим донтолоос урьдчилан сэргийлэх, зөв, зохиистой хэрэглээг дадал болгоход эцэг эхийн үүрэг их чухал нөлөөтэй билээ.

ГБХЗХГ-ийн “Хүүхдийн хөгжил, төлөвшил, хүмүүжилд сөрөг нөлөө үзүүлж болох хүчин зүйлсийг тодорхойлох” 2019 оны суурь судалгаагаар дараах үр дүн гарчээ.

График 1.



Дээрх үр дүнгүүдээс харахад эцэг эхчүүдээс “Та хүүхдийнхээ цахим хэрэглээнд хяналт тавьдаг, тохируулга, арга хэрэгслийг мэдэх үү” гэсэн асуултанд огт мэдэхгүй гэж 75%, зарим талаар гэж 18% хариулжээ. “Та хүүхдийнхээ цахимаар юу үзэж харж байгааг мэдэх үү” гэсэн асуултанд огт мэдэхгүй гэж 42%, зарим талаар мэднэ гэж 42% хариулсанаас үзэхэд эцэг эхчүүдийн зүгээс хүүхдийнхээ цахим хэрэглээнд хяналт тавьж чаддаггүй болох нь харагдаж байна. “Та гэртээ хүүхдүүд цахимаар сөрөг агуулга үзэхгүй байх нөхцөлөөр хангасан уу” гэсэн асуултанд хангаагүй гэж 30%, зарим талаар гэж 45%, “Та хүүхдээ сошиалаар ирэх дарамт ялгаварал, хүчирхийлэлд өртөхөөс хамгаалж чадах уу” гэсэн асуултанд чадахгүй гэж 29.1%, зарим талаар гэж 41.1% хариулсанаас үзэхэд хүүхдийн хүмүүжил, төлөвшилд цахим орчноос ирэх сөрөг нөлөөллөөс хамгаалах талаар эцэг эхчүүд хангалттай мэдлэггүй байгаа нь харагдаж байна.

Шигтгээ: Хүүхдийн аюулгүй байдалд гэр бүлийн орчинд хангагдаж чадахгүй байгаа нь эцэг эхчүүд хүүхдээ үл хайхрах, цахим орчны хяналт тавьж чаддаггүй, архины хамаарал, үлгэрлэл дуурайлалгүй, эцэг эх болоход бэлтгэгдээгүй, хүмүүжүүлэх эерэг арга барил эзэмшээгүй зэрэг олон хүчин зүйл нөлөөлж байна.

ГБХЗХГ-ийн мэргэжилтэнтэй хийсэн ганцаарчилсан ярилцлагаас

СЭМҮТ-ийн статистик тайлангаас харахад 2013 онд жилдээ 31, 2014 онд 47, 2015 онд 41, 2016 онд 68, 2017 онд 94, 2018 онд 56 хүүхэд цахим тоглоомонд донтсон гэх шалтгаанаар хэвтэн эмчлүүлсэн байна. 2017 онд 2100 хүүхэд Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвд СЭМҮТ хэвтэн эмчлүүлснээс 357 хүүхэд РС тоглоом, дэлгэцийн донтолтоос хамааралтай гэсэн оноштой байжээ. 2000 оны эхээр 3,4-хөн байсан бол харин 2021 онд 90-100 хүүхэд хэвтдэг болсон байна. 90-98 хувь

нь эрэгтэй хүүхдүүд. 13-15 насны хүүхдүүд зонхилж хэвтэж байна. Цахим тоглоомоор тоглосоноор эцэг эхчүүдийн хүүхдэдээ анхаарах анхаарал халамж нь багасч, харин хүүхдүүдийн тухайд хүүхдийн хүмүүжил ёс суртахуун, сэтгэл зүйд нөлөөлж, хүүхэд гэмт хэрэгт холбогдох, гэмт хэргийн золиос болох тохиолдол ч байдаг аж.

Дүгнэлт

Хүүхдийн аюулгүй байдлыг хангах асуудлыг хариуцах эзэнтэй болгох шаардлага байна. Тухайлбал, эцэг эхчүүдэд хариуцуулж, арга хэмжээ авах хэрэгтэй байгаа бөгөөд эцэг эх нь өөрсдийн аюулгүй байдлаа хангаад ажиллаад байдаг боловч үүний ард хүүхэд нь гэртээ болон гадаад орчны аюулд өртөөд байгаад олон нийтийн анхаарлыг хандуулах шаардлагатай байна. Гэр бүлийн орчин хүүхдийн аюулгүй байдлыг хангаж чадахгүй байгаа нь хүүхдийн осол гэмтэл, гэр бүлийн хүчирхийлэл, гэр бүлийн таагүй орчин, эцэг эхийн хараа хяналт сул байдал, хүүхэд хамгааллын тогтолцоо бүрэн бүрдэж, үйл ажиллагаа нь жигдрээгүй, ахуйн хүрээний архидалт, нийтийн сүлжээний хяналтгүй байдал, хохирогчийн гэнэн итгэмтгий зан зэрэг байна.

Гэр орон, ахуйн нөхцөлд хайхрамж болгоомжгүй байдлаас үүдсэн осол гэмтлийг бууруулах, хүн амын мэдлэг, хандлагыг өөрчлөн зохистой зан үйлийг төлөвшүүлж, эцэг эхчүүдэд мэдлэг мэдээлэл, анхааруулга зөвлөмж өгөх шаардлага тулгарч байна. Тэгэхээр аюулгүй байдлын дадлага, сургалтыг эртнээс явуулж хүүхэд ахуй цагаас нь суулгах нь зүйтэй. Монгол хүүхдийн аюулгүй байдлыг уламжлалт хандлага дээр үндэслэн орчин үеийн суурьшмал буюу хот суурин өндөр технологийн эринтэй нийцүүлж аюулгүй байдлаа хангах арга барилд сургах нь зүйтэй гэж үзэж байна. Эцэг эхчүүдийг хүүхдүүддээ аюулгүй байдлын дүрмүүдийг сургаж, заавал хэвшүүлээрэй гэж заасан байдаг боловч гэр бүлдээ хүүхдийн аюулгүй байдлыг хангах тал дээр мэдээлэл, сургалтын үйл ажиллагаа дутмаг байна. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн суурь ойлголтыг хүүхдийн нас биеийн онцлогт нийцүүлэн цаашид улам нарийвчлан судлах нь зайлшгүй болжээ.

Ашигласан эх сурвалж:

1. Гидденс, А. (2006). Социологи. УБ. 2.
2. Гурова, Р.Г. (1986). Хүмүүжлийн социологийн асуудлууд. УБ.,27
3. ГССҮТ, СТСА. Осол гэмтлийн тандалтын тайлан. УБ., 2017-2022
4. Дюррант.Е., Жоан.(2008) Хүмүүжлийн эерэг аргууд Юу? яаж?. УБ
5. З. Лукашевич, М.П. (1996). Социология воспитания. Киев.
6. Мөнхбат, О. (2004). О.Контын позитивист социологийн үзэл баримтлал. Социологи.
7. Мөнхбат, О. (2007). Бүтэц-функциональ онолын үзэл баримтлал. Социологи
8. Радугин, А.А, Р. (2003). Социологи. УБ. 9. Радугин, А.А, Р. (2003). Социологи. УБ.
9. ЗЦГ-ын статистик мэдээ;(2017) НЭМҮТ, Хүүхдийг зам тээврийн ослоос урьдчилан сэргийлэх өдөр
10. ЗЦГ. Тогтвортой хөгжил- Ерөнхий боловсрол” үндэсний зөвлөгөөн . УБ. 2018
11. Социологи, Агуу санааг энгийнээр тайлбарлах нь, (2018). УБ
12. Тогтвортой хөгжил- Ерөнхий боловсрол” үндэсний зөвлөгөөн (2018); ЗЦГ-ын статистик мэдээ
13. ХИС. (2018)Монгол улс дахь хүүхдийн эрхийн нөхцөл байдлын үнэлгээ. УБ.
14. ҮСХ. (2020). Хүн ам, орон сууцны 2020 оны тооллого.УБ.
15. ҮСХ,(2017/12) Монгол Улсын нийгэм, эдийн засгийн байдал. УБ.
16. ҮСХ, ЦЕГ. Гэр бүлийн хүчирхийлэл. Статистийн тойм., УБ.,2020
17. ҮСХ. Хүн ам-Статистикийн мэдээллийн нэгдсэн сан. .УБ., 2022
18. ҮСХ. Статистикийн мэдээ. УБ., 2022.
19. ҮСХ, Ц. (2020). Гэр бүлийн хүчирхийлэл. Статистийн тойм. УБ.
20. ХНХЯ. Хүүхэд хамгааллын хамтарсан баг. УБ., 2016